



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ

2017 оны 01 сарын 20 өдөр

Дугаар 17

Мөрөн

“Хөвсгөл Эрчим Хүч” ХХК-ийн 2017 оны бизнес
төлөвлөгөөг батлах чиглэл өгөх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.3 “к” заалт, Компанийн тухай 62 дугаар зүйлийн 62.1.10, 62.1.15, 62.1.16 дахь заалтууд, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 47 дугаар тогтоол, Монгол Улсын Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоолыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. “Хөвсгөл Эрчим Хүч” ХХК-ийн 2017 оны бизнес төлөвлөгөөний төсөлд тусгагдсан үйл ажиллагааны зардлуудаас бууруулах болон хасах зардлын жагсаалт, түүний хэмжээг хавсралтаар баталж, Мөрөн сумын хог зайлуулах үйлчилгээний нийт төлбөрийн орлогын 10 хувьтай тэнцэх хэсгийг тус компанийн орлогод төвлөрүүлсүгэй.

2. Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаас бууруулах болон хасахаар тооцон баталсан зардлуудыг тогтоосон хэмжээгээр бууруулах, зарим зардлыг нягтлан шалгах, орлогыг бодитой тооцох замаар “Хөвсгөл Эрчим Хүч” ХХК-ийн 2017 оны бизнес төлөвлөгөөг батлахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга /Д.Пүрэвдорж/-д даалгасугай.

3. “Хөвсгөл Эрчим Хүч” ХХК-ийн Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан зөвлөх үйлчилгээ болон 10,0 сая төгрөгөөс дээш төсөвт өртөг бүхий бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааг аймгийн Орон нутгийн өмчийн газарт нэгтгэн зохион байгуулахыг Орон нутгийн өмчийн дарга /Б.Болд/-д даалгасугай.

010057

4. "Хөвсгөл Эрчим Хүч" ХХК-ийн 2017 оны хөрөнгө оруулалт, их засварын ажлын төлөвлөгөөг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд хэлэлцүүлэхийг аймгийн Засаг дарга /Л.Ганболд/-д даалгасугай.

5. Тогтоолын биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Цогтоо/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР

"ХӨВСГӨЛ ЭРЧИМ ХҮЧ" ХХК-ийн 2017 ОНЫ БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТӨСӨЛД
ТУСГАГДСАН ЗАРДЛУУДААС БУУРАУУЛАХ БОЛОН ХАСАХ ЗАРДЛЫН ЖАГСААЛТ, ХЭМЖЭЭ

д/д	Зардлын ангилал	Хасах болон бууруулах зардлын хэмжээ төгрөгөөр	Тайлбар
1	Бүтэц, орон тоо		110 хүнээр батлах. Мөрөн сумын авто замын гэрэлтүүлгийн "Хөвсгөл Эрчим хүч" ХХК-д шилжих тул гэрэлтүүлэг хариуцсан ажилтны орон тоог нэмэгдүүлж батлах
2	Цалин, шагналт цалингийн зардал	5,400,000	2017 онд удирдлагын багийн цалинг 50.000 төгрөгөөр нэмэгдүүлэхгүй хасч, жилийн эцсийн үр дүнг тооцож урамшуулал олгохоор гэрээнд тусгах. /Захирал, Ерөнхий инженер, СХЕМенежер, Борлуулалтын ахлах инженер, ШСДС-ийн ахлах инженер, Эдийн засагч, ХНМенежер, ХАБЭАИнженер, ДРХ-ынинженер/
		200,975,711	Сарын үр дүнгийн шагналт цалингаас 200.975.711 төгрөгийг хасч сарын үр дүнгийн шагналт цалин 111.0 сая төгрөгөөр батлах.
3	13 дахь сарын цалингийн зардал	55,312,622.0	Хасч батлах.
4	Түлээний хөнгөлөлтийн зардал		Түлшний хөнгөлөлт дахин төлөвлөж байранд амьдардаг өрхийн түлээний хөнгөлөлтийг хасч батлах.
5	Тэтгэмж тусламжийн тооцоо	8,534,000.0	Тэтгэмж тусламжийн тооцоо гэсэн нэрийг 1 удаагийн буцалтгүй тусламжийн зардал болгон нэрийг өөрчлөх 8.534.000 төгрөгийг хасах 8.500.000 төгрөгөөр батлах.
6	Шагнал урамшууллын зардал	6,064,000.0	ЭХ-ний тэргүүний ажилтан цол тэмдэгт олгох ажилтан 2,880,000 төгрөг, ЭХ-ний тэргүүний ажилтан цол тэмдэгт ахмадуудад олгох 1,684,000 төгрөг, Байгууллагын хүндэт дэвтэрт бичигдсэн ажилтанд олгох 1,500,000 төгрөг нийт зардал 6.064.000 төгрөгийг хасч батлах.
		6,000,000.0	Шинэ жил тэмдэглэх үйл ажиллагааны зардлыг хасч батлах.
7	2017 Шатах тослох материалын зардал	15,869,000.0	Шатах тослох материалыг 30 хувь буюу 15.869.000 төгрөгийг хасч 37.027.745 төгрөгөөр батлах
8	2017 оны сэлбэг хэрэгслийн зардал	1,679,000.0	ШинэЛанд 200 автомашины сэлбэг авах зардал 1.679.000 төгрөгийг хасч сэлбэгд 2.000.000 төгрөгийг батлах.

9	2017 оны албан томилолтын зардал		Захирал нийт 72 хоног, Ерөнхий инженер 31 хоног ТОМИЛОЛТООР ажилахаар байна. Анхаарах. 2017 оны албан томилолтын зардал тодорхой хэжээгээр бууруулж батлах.
10	2017 оны ХӨЛБӨӨНИЙ зардал	1,200,000	Суурин утастай ажилчдын гарутасны нэгжний үнийг хасаж батлах.
11	2017 оны сургалтын зардал	7,622,000	ИТА албан хаагч \10 хүн\ 1000.000 төгрөг, Оюутны төлбөр 1.900.000 төгрөг, Харилцаа хандлага хувь хүний хөгжил 2.000.000 төгрөг нийт 4.900.000 төгрөгийг баталж 7.622.000 төгрөгийг хасч батлах.
12	2017 оны Хөдөлмөр хамгааллын зардал		48.485.000 төгрөгийг дахин тооцох. Нормын хувцасны эдэлгээний хугацааг хянах.
		10,000,000	Галын дохиоллын 10 сая төгрөгийг хасч 2.000.000 төгрөгийг батлах
		10,500,000	Эрүүл мэндийн үзлэгийг нэг хүнийг 10.000 төгрөгөөр тооцож аймгийн нэгдсэн эмнэлэгт үзүүлэх.
			ХАБ-ын инженерийн хуучин компьютерыг ИТХ-д балансаар шилжүүлэх.
		9,000,000	ХАБ-ын инженер сургалтаа өөрөө зохион байгуулж 9.000.000 төгрөгийг хасч батлах
13	ТУЗ-ийн зардал		44.517.920 төгрөгөөр батлаж төлөвлөгөөнд тусгах
4	Хөрөнгө оруулалт	1,000,000	500.000 төгрөгөөр 2 ширхэгийг авах төмөр сейфыг хасах
		400,000	1 ш 400.000 төгрөгөөр авах факсын аппаратыг хасах
		600,000	2 ш 300.000 төгрөгөөр авах сейф/саарал, шилэн хаалгатай, хувцасны өлгүүртэй/-ыг хасах
		300,000	1 ш 300.000 төгрөгөөр авах хувцасны шкафыг хасах
		5,200,000	4 ш 1.300.000 төгрөгөөр авах суурин компьютерыг хасах
		6,000,000	4 ш 1.500.000 төгрөгөөр авах Notebookийг хасах
		6,400,000	80 ш 80.000 төгрөгөөр авах сандалыг хасах
		4,400,000	2 ком 2.200.000 төгрөгийн угтвар ширээ сандалыг хасах
		11,000,000	1 ш 11.000.000 төгрөгийг бүтэн моторыг хасах
Нийт		373,456,333	